



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 06 сарын 05 өдөр


Дугаар A/34

Улаанбаатар хот

Нэхэн ажиллуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэг, Засгийн газрын 2025 оны 109, 279 дүгээр “Ажил амралтын цагийг зохицуулах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын үндэсний уламжлалт баяр, Цагаан сар болон Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын өдрүүд Бямба, Ням гаригт тохиож байгаатай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын нийт албан хаагчдыг цаг үеийн ажлын ачааллыг харгалзан 2025 ондоо багтаан Бямба, Ням гаригт 4 өдөр нэхэн ажиллуулсугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Н.Ганболд)-т даалгасугай.



132003209